

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/13



Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн Даргаар Цэвэгжавын Одмааг сонгосугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн Дарга (Ц.Одмаа)-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Дарга сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудсан дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ТУЗ-ийн гишүүнүүд:

	/О.БОЛДБААТАР/		/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
	/В.БАЯРСАЙХАН/		/Ц.ОДМАА/
	/Н.ЦЭВЭЭМҮРЛ/		/С.ЭНХ-АМГАЛАН/
	/С.БОРГИЛ/		/Ж.ЖАРГАЛСҮРЭН/
	/Ч.НОМИН/		

УЛААНБААТАР ХОТ
8001764 ± 1118257208

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/14

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргыг улируулан томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 13 дугаа зүйлийн 13.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, ТУЗ-ийн Даргын 2020 оны 4 сарын 29-ний өдрийн санал, ТУЗ-ийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Жаргалсайханы Мөнхцэцэгийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар улируулан томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудсан дахь мэдээлэл холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/15

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

- a. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо:

Хорооны дарга: Б.Дэлгэржаргал;
Гишүүд: С.Энх-Амгалан;
Н.Цэвэгмид;
О.Болдбаатар;
В.Баярсайхан;
Ч.Номин.

- b. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: Ж.Жаргалсүрэн;
Гишүүд: С.Боргил;
Ц.Олмаа.

- c. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: С.Энх-Амгалан;
Гишүүд: С.Боргил;
Ч.Номин.

2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/16

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны ээлжит хурлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.8 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2020 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д, түүнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Ц.Одмаа)-д үүрэг болгосугай.



ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 4 сарын 29-ний өдрийн 20/16 тоот тогтоолын Хавсралт 1



ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2020 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУВААРЬ

	ТУЗ-ийн ээлжит хурал	Огноо	Гариг
1	I улирлын ээлжит хурал	2020 оны 4 сарын 29	Лхагва
2	II улирлын ээлжит хурал	2020 оны 7 сарын 29	Лхагва
3	III улирлын ээлжит хурал	2020 оны 10 сарын 21	Лхагва
4	IV улирлын ээлжит хурал	2020 оны 12 сарын 23	Лхагва
5	2020 оны жилийн эцсийн хурал	2021 оны 2 сарын 05	Баасан

ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/17

Улаанбаатар хот

Үнэт цаас нийтэд санал болгон гаргах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйл 6.1 дэх хэсэг, "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Компанийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийтэд санал болгох өрийн бичгийн ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
3. Компанийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан үнэт цаасны зах зээлд оролцогч бусад эрх бүхий этгээдтэй энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан нөхцөлийн хүрээнд холбогдох хэлцэл хийх, гэрээ байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
4. Компанийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргахтай холбоотой судалгаа, шилжилгээ хийх, тэдгээрийн үйл явц, хэрэгжилт, үр дүнг ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
5. Компанийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

/О.ОДМАА/

ГИШУУД:

/Н.ЦЭВЭГМИД/

/О.БОЛДБААТАР/

/Ч.НОМИН/

/С.БОРГИЛ/

/В.БАЯРСАЙХАН/

/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/18

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл
хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 болон 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.12 дахь хэсэг, ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/04 тоот тогтоол, уг тогтоолын 1 дүгээр Хавсралтаар батлагдсан Компанийн "2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөө", ТУЗ-ийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 03-ны өдрийн 20/04 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Компанийн "2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөө"-ний хүрээнд Нийтэд санал болгох үнэт цаас гаргахад хамтран ажиллах ерөнхий Андеррайтераар "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-ийг сонгосугай.
2. "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-тай хамтран ажиллахад шаардлагатай Андеррайтерийн болон Зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлийг тодорхойлох, гэрээ байгуулах, түүнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасантай холбогдуулан эх үүсвэр амжилттай татан төвлөрүүлсэн тохиолдолд "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-д төлөх үйлчилгээний төлбөрийг амжилттай татан төвлөрүүлсэн хөрөнгийн 1 (нэг) хүртэл хувь байхаар тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-тай байгуулах Андеррайтерийн болон Зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



ТУЗ-ийн дарга:

/Ц.ОДМАА/

ТУЗ-ийн гишүүн:

/С.БОРТИН/

/В.БАЯРСАЙХАН/

/О.БОЛДБААТАР/

/В.ДЭЛГЭРЖАРГАЛ/

/Ч.НОМИН/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/19

Улаанбаатар хот

Хэлцэл хийснийг зөвшөөрч,
баталгаажуулах тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, "ЛэндМН ББСБ" ХК (наашид "Компани" гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан 2019 оны 5 сарын 10-ны өдөр Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Хадгаламж барьцаалсан зээлийн гэрээг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан нөхцөлийн дагуу сунгаж, Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-ын 2020 оны 4 сарын 24-ний өдөр Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Хадгаламж барьцаалсан зээлийн гэрээний нэмэлт гэрээг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Зээлийн гэрээний нэмэлт гэрээний хэрэгжилтийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ТҮЗ-ИЙН ДАРГА:



ГИШҮҮҮР


 /Н.ЦЭВЭГМИД/


 /О.БОЛДБААТАР/


 /Ч.НОМИН/

 /С.БОРГИЛ/

 /В.БАЯРСАЙХАН/

 /В.ДЭЛГЭРЖАРГАЛ/

 /С.ЭНХ-АМГАЛАН/

 /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

ЛЭНДМН ББСБ" ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/20

Улаанбаатар хот

Хэлцэл хийснийг зөвшөөрч,
баталгаажуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.5 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, "ЛэндМН ББСБ" ХК (цаанхид "Компани" гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 20.5 болон 20.6 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 29-ний одрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан "Анд Системс Тех" ХХК-тай 2019 оны 11 сарын 01-ний өдөр байгуулсан "ЗГ 19/29" тоот Зээлийн гэрээнд энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан нөхцөлөөр нэмэлт, өөрчлөлт оруулж, Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-ын "Анд Системс Тех" ХХК-тай 2020 оны 2 сарын 03-ны өдөр байгуулсан "ЗГ 19/29-1" тоот Зээлийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан "Анд Системс Тех" ХХК-тай байгуулсан "ЗГ 19/29-1" тоот Зээлийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээний хэрэгжилтийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.


_____/С.БОРГИЛ/
_____/Ч.НОМИН/

_____/С.ЭНХ-АМГАЛАН/
_____/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөгч Удирдах Зөвлөлийн
2020 оны 4 сарын 29-ний өдрийн $\frac{29}{720}$ тоот тогтоолын Хавсралт 1



“АНД СИСТЕМС ТЕХ” ХХК-ТАЙ БАЙГУУЛСАН
“ЗГ 19/29-1” ТООТ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭНИЙ НОХЦӨЛ

Зээлийн үнийн дүн	4,000,000,000 тэрбум хүртэл төгрөг
-------------------	------------------------------------

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/21

Улаанбаатар хот


Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1, 89.1.3 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 болон 20.5 дахь хэсэг, Санхүүгийн Тогтвортой Байдлын зөвлөлийн 2020 оны 3 сарын 17-ны өдрийн хурлын шийдвэр, Гүйцэтгэх удирдлагаас гаргасан саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Анд Системс Тех” ХХК-тай 2017 оны 7 сарын 03-ны өдөр байгуулсан Үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах “Нэмэлт гэрээ”-г байгуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д зөвшөөрсүгэй.
2. Нэмэлт гэрээний хэрэгжих хугацааг 2020 оны 4 сарын 01-ний өдрөөс эхлэн Үйлчилгээний гэрээний хугацаа дуусах хүртэл хугацаанд үргэлжлүүлэхээр тогтоосугай.
3. “Анд Системс Тех” ХХК-тай байгуулсан “Нэмэлт гэрээ”, түүний хэрэгжилтийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



/С.БОРГИЛ/



/Ж.ЖАРГАЛСҮРЭН/



ГҮЗНИЙН ГИШҮҮД:

/Ч.НОМИН/



/С.ЭНХ-АМГАЛАН/

ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 29-ний өдөр

№ 20/22

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 144/125 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6.4 дэх заалт, "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн 124,000,000 (нэг зуун хорин дөрвөн сая) хүртэлх төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдох 10,000,000 (арван сая) хүртэлх төгрөгийн төлөгдөөгүй шимтгэлийн авлагын хамтаар Компанийн Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, ийнхүү хорогдуулсантай холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2020 оны 4 сарын 30-ны өдөрт багтаан хийх эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
2. Компанийн Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын шаардлагуудад нийцүүлэн хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

